



МОНГОЛ УЛСЫН ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ
УЛСЫН 11 ДУГААР САРЫН 04
№41 /662/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

Монгол Улсын
Засгийн газрын
Зөвлөлийн
Зарлиг

1653

**Зарим хүмүүсийг шүүгчийн
албан тушаалд томилох тухай**

Монгол Улсын
Засгийн газрын
тогтоол

1655

**Олборлох үйлдвэрлэлийн ил тод
байдлын санаачилгын тухай**

Монгол Улсын
Засгийн газрын
тогтоол

1657

Төсвийн хязгаар батлах тухай

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

346.	Зарим хүмүүсийг шүүгчийн албан тушаалд томилох тухай	Дугаар 209	1653
347.	Зарим хүмүүсийг шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай	Дугаар 210	1654
348.	Шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх тухай	Дугаар 211	1654
349.	Б.Цэрэнбалтавыг албан тушаалаас чөлөөлөх тухай	Дугаар 212	1654

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

350.	Олборлох үйдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын тухай	Дугаар 190	1655
351.	Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай	Дугаар 192	1655
352.	Тогтоод өөрчлөлт оруулах тухай	Дугаар 193	1657
353.	Төсвийн хязгаар батлах тухай	Дугаар 194	1657
354.	Түр журам батлах тухай	Дугаар 197	1664
355.	Төлөвлөгөө батлах тухай	Дугаар 202	1668

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2010 оны 10 дугаар сарын 13-ны өдөр

Дугаар 209

Улаанбаатар хот

Зарим хүмүүсийг шүүгчийн албан тушаалд томилох тухай

"Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 32 дугаар зүйлийн 32.1, 32.2 дахь хэсэгт заасныг баримтлан, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Цэвэгмидийн Зоригийг Улсын Дээд шүүхийн шүүгчийн, Нолын Болормааг Дорноговь аймгийн шүүхийн шүүгчийн, Гунаагийн Сүрэнг Сүхбаатар аймгийн шүүхийн шүүгчийн, Намжилцэрэнгийн Дэлгэрмааг Завхан аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ

Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2010 оны 10 дугаар
сарын 13-ны өдөр

Дугаар 210

Улаанбаатар
хот

Зарим хүмүүсийг шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай

"Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 58 дугаар зүйлийн 58.1.2 дэх хэсэгт заасныг баримтлан, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Төрийн өөр ажил, албан тушаалд томилогдсон тул Цэвэгмидийн Зоригийг Нийслэлийн шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн, Нолын Болормааг Архангай аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Гунаагийн Сүрэнг Сүхбаатар аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

ЦЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2010 оны 10 дугаар
сарын 13-ны өдөр

Дугаар 211

Улаанбаатар
хот

Шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх тухай

"Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 57 дугаар зүйлийн 57.1.5, 78 дугаар зүйлийн 78.4 дэх хэсэгт заасныг тус тус баримтлан, Шүүхийн Ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Төв аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгч Доржхорлоогийн Оюунжаргалыг эрүүгийн хариуцлагад татах зөвшөөрөл олгож, Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасны дагуу эрх бүхий байгууллагаас зохих шийдвэр гарах хүртэл шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

ЦЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2010 оны 10 дугаар
сарын 14-ний өдөр

Дугаар 212

Улаанбаатар
хот

Б.Цэрэнбалтавыг албан тушаалаас чөлөөлөх тухай

Монгол Улсын Үндсэн хуулийн гучин дөрөвдүгээр зүйлийн 1, Прокурорын байгууллагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.7.2. дахь заалтыг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

Бат-Очирын Цэрэнбалтав чөлөөлөгдөх тухай хүсэлтээ гаргасныг нь үндэслэн түүнийг Улсын ерөнхий прокурорын орлогчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙЛӨГЧ**

ЦЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2010 оны 7 дугаар
сарын 14-ний өдөр

Дугаар 190

Улаанбаатар
хот

Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлыг Монгол Улсад хэрэгжүүлэх ажлын үр нөлөөг дээшлүүлэх зорилгоор холбогдох зардлыг 2011 оноос эхлэн Монгол Улсын Ерөнхий сайдын төсвийн багцад жил бүр тусган санхүүжүүлж байх арга хэмжээ авахыг Сангийн сайд С.Баярцогтод даалгасугай.

2. Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын хүрээнд ашигт малтмалын ашиглалтын болон хайгуулын тусгай зөвшөөрөл эзэмшигчээс орон нутгийн төсөвт төлж байгаа татвар, төлбөр, хураамж, торгууль зэрэг орлого болон аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар, төсөвт байгууллагад хандивлаж байгаа мөнгөн болон мөнгөн бус хөрөнгийн тайланг холбогдох маягтын дагуу жил бүр гаргаж, нийтэд мэдээлж, журмын дагуу тайлагнаж байхыг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

САНГИЙН САЙД

С.БАЯРЦОГТ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2010 оны 7 дугаар
сарын 14-ний өдөр

Дугаар 192

Улаанбаатар
хот

Тогтоолын хавсралтад нэмэлт оруулах тухай

Химийн хорт болон аюултай бодисын тухай хуулийн 6.4-т заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Жагсаалт батлах тухай" Засгийн газрын 2007 оны 4 дүгээр сарын 11-ний өдрийн 95 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан "Монгол Улсад ашиглахыг хориглосон химийн хорт болон аюултай бодисын жагсаалт"-д дор дурдсан агуулга бүхий "84" дэх заалт нэмсүгэй:

84	Бүх төрлийн асбест /дөрмөсөн чулуул/	Asbestos			Дулаан тусгаарлах, галаас хамгаалах болон нягтруулах, битүүмжлэх зэрэг зориулалтаар, мөн асбестан утас, хавтан, хоолой, тэнэг төхөөрөмж, машины үйлдвэрлэл болон ундаа, эмийн үйлдвэрийн шүүгч материал	Нэг, амьсгалын замын эрхтэн, системийг гэмтээж, хорт каадар үүсгэнэ
	Амфиболууд	Amphibole forms	1332-21-4			
	-Актинолит	-Actinolite (Ca ₂ (Mg,Fe) ₇ Si ₈ O ₂₂ (OH) ₂)	77536-66-4			
	-Антофеллит	-Anthophyllite (Mg, Si ₆ O ₁₀ (OH) ₂)	77536-67-5			
	-Амосит	-Amosite (Fe, Ni) ₂ Si ₄ O ₁₀ (OH) ₂	12172-73-5			
	-Кроцидолит	-Crocidolite (Mg, Si, O ₁₀ (OH) ₂)	12001-28-4			
	-Тремолит	-Tremolite (Ca, Mg, Si, O ₁₀ (OH) ₂)	77536-68-6			

2. Асбест болон асбестан бүтээгдэхүүний импортод тавигдах хилийн мэргэжлийн болон гаалийн хяналтыг сайжруулан ажиллахыг Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга Я.Содбаатар, Гаалийн ерөнхий газрын дарга Д.Цэвээнжав нарт үүрэг болгосугай.

3. Асбестын хэрэглээг үе шаттайгаар зогсоож, ашиглалтаас гарсан материалыг хүний эрүүл мэнд, байгаль орчинд халгүй аргаар цуглуулж, устгах арга хэмжээ авахыг Зам, тээвэр, барилга, хот байгуулалтын сайд Х.Баттулга, Байгаль орчин, аялал, жуулчлалын сайд Л.Гансүх нарт үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН САЙД**

Л.ГАНСҮХ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2010 оны 7 дугаар
сарын 20-ны өдөр

Дугаар 193

Улаанбаатар
хот

Тогтоолд өөрчлөлт оруулах тухай

Улсын Их Хурлын 2009 оны 99 дүгээр тогтоолын 2 дугаар зүйлийн 4 дэх заалтыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

"Иргэнд хишиг, хувь хүртээхтэй холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай" Засгийн газрын 2010 оны 1 дүгээр сарын 6-ны өдрийн 3 дугаар тогтоолын 3 дугаар зүйлийг дор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

"3. 2010 онд Монгол Улсын иргэнд хүртээх хишиг, хувийг 2 хуваан олгож, үүнээс эхний ээлжийн 70.0 (далан) мянган төгрөгийг 2010 оны 2 дугаар сарын 1-ний өдрөөс, үлдэх хэсгийг 2010 оны 8 дугаар сарын 1-нээс эхлэн сар бүр тэнцүү хэмжээгээр хуваан олгох ажлыг зохион байгуулахыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Т.Гандид, уг арга хэмжээнд шаардагдах хөрөнгийг тухай бүрт нь санхүүжүүлэх арга хэмжээ авч ажиллахыг Сангийн сайд С.Баярцогтод тус тус даалгасугай".

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**НИЙГМИЙН ХАМГААЛАЛ,
ХӨДӨЛМӨРИЙН САЙД**

Т.ГАНДИ

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2010 оны 7 дугаар
сарын 20-ны өдөр

Дугаар 194

Улаанбаатар
хот

Төсвийн хязгаар батлах тухай

Улсын Их Хурлын 2010 оны 40 дүгээр тогтоолыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Төсвийн ерөнхийлөн захирагч бүрийн 2011 оны төсвийн хязгаар болон 2012-2013 оны төсвийн хязгаарын төсөөллийг хавсралт ёсоор баталсугай.

2. Батлагдсан төсвийн хязгаарт багтаан 2011 оны төсвөө боловсруулахыг Төсвийн ерөнхийлөн захирагч нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

САНГИЙН САЙД

С.БАЯРЦОГТ

Засгийн газрын 2010 оны 194 дүгээр
тогтоолын хавсралт

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ НАРЫН
2011 ОНЫ ТӨСВИЙН ХЯЗГААР

Төсвийн ангилал	Төсвийн хязгаар	Төсвийн төсөөлөл	
	2011	2012	2013

А. УЛСЫН ТӨСӨВ

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА	3,274.0	3,624.3	3,801.1
Урсгал зардал	3,084.8	3,414.8	3,581.4
Хөрөнгийн зардал	189.2	209.4	219.7
Эргэж төлөгдөх цэвэр зээл	-	-	-
МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА	12,748.8	14,112.9	14,801.4
Урсгал зардал	12,108.8	13,404.5	14,058.3
Хөрөнгийн зардал	640.0	708.5	743.0
Эргэж төлөгдөх цэвэр зээл	-	-	-
МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДАРГА	417.4	462.0	484.6
Урсгал зардал	371.7	411.4	431.5
Хөрөнгийн зардал	45.7	50.6	53.1
Эргэж төлөгдөх цэвэр зээл	-	-	-
УЛСЫН ДЭЭД ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ШҮҮГЧ	1,070.4	1,185.0	1,242.8
Урсгал зардал	951.6	1,053.5	1,104.8
Хөрөнгийн зардал	118.8	131.5	137.9
Эргэж төлөгдөх цэвэр зээл	-	-	-
ШҮҮХИЙН ЕРӨНХИЙ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА	11,478.6	12,706.8	13,326.7
Урсгал зардал	11,129.7	12,320.6	12,921.6

Хөрөнгийн зардал	348.9	386.2	405.1
Эргэж төлөгдөх цэвэр зээл	-	-	-
УЛСЫН ЕРӨНХИЙ ПРОКУРОР	7,956.9	8,808.3	9,237.9
Урсгал зардал	7,920.4	8,767.9	9,195.6
Хөрөнгийн зардал	36.5	40.4	42.4
Эргэж төлөгдөх цэвэр зээл	-	-	-
ҮНДЭСНИЙ АЮУЛГҮЙ БАЙДЛЫН ЗӨВЛӨЛИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА	957.8	1,060.3	1,112.0
Урсгал зардал	852.5	943.7	989.8
Хөрөнгийн зардал	105.3	116.6	122.3
Эргэж төлөгдөх цэвэр зээл	-	-	-
МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД	78,383.7	86,770.7	91,003.4
Урсгал зардал	36,194.6	40,067.5	42,022.0
Хөрөнгийн зардал	42,189.0	46,703.2	48,981.5
Эргэж төлөгдөх цэвэр зээл	-	-	-
МОНГОЛ УЛСЫН ТЭРГҮҮН ШАДАР САЙД	14,793.6	16,376.5	17,175.3
Урсгал зардал	10,793.6	11,948.5	12,531.3
Хөрөнгийн зардал	4,000.0	4,428.0	4,644.0
Эргэж төлөгдөх цэвэр зээл	-	-	-
МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД	60,291.8	66,743.0	69,998.8
Урсгал зардал	46,585.8	51,570.5	54,086.1
Хөрөнгийн зардал	13,706.0	15,172.5	15,912.7
Эргэж төлөгдөх цэвэр зээл	-	-	-
МОНГОЛ УЛСЫН САЙД, ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА	11,421.8	12,643.9	13,260.7
Урсгал зардал	9,187.1	10,170.1	10,666.2
Хөрөнгийн зардал	2,234.7	2,473.8	2,594.5
Эргэж төлөгдөх цэвэр зээл	-	-	-
ГАДААД ХАРИЛЦААНЫ САЙД	29,167.5	32,268.5	33,863.5



Урсгал зардал	24,846.1	27,504.7	28,846.4
Хөрөнгийн зардал	4,321.4	4,783.8	5,017.1
Эргэж төлөгдөх цэвэр зээл	-	-	-
САНГИЙН САЙД	217,357.4	240,614.7	252,352.0
Урсгал зардал	196,334.9	217,342.7	227,944.8
Хөрөнгийн зардал	11,600.1	12,841.3	13,467.7
Эргэж төлөгдөх цэвэр зээл	9,422.5	10,430.7	10,939.5
ХУУЛЬ ЗҮЙ, ДОТООД ХЭРГИЙН САЙД	165,822.5	183,565.5	192,520.0
Урсгал зардал	144,562.4	160,030.6	167,837.0
Хөрөнгийн зардал	21,260.1	23,534.9	24,683.0
Эргэж төлөгдөх цэвэр зээл	-	-	-
БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД	32,775.3	36,282.2	38,052.1
Урсгал зардал	21,801.3	24,134.1	25,311.3
Хөрөнгийн зардал	10,973.9	12,148.1	12,740.7
Эргэж төлөгдөх цэвэр зээл	-	-	-
БАТЛАН ХАМГААЛАХЫН САЙД	82,306.6	91,113.4	95,558.0
Урсгал зардал	79,022.8	87,478.3	91,745.5
Хөрөнгийн зардал	3,283.8	3,635.2	3,812.5
Эргэж төлөгдөх цэвэр зээл	-	-	-
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ САЙД	588,078.8	651,003.3	682,759.5
Урсгал зардал	518,009.3	573,436.3	601,408.8
Хөрөнгийн зардал	70,069.5	77,567.0	81,350.7
Эргэж төлөгдөх цэвэр зээл	-	-	-
ЗАМ, ТЭЭВЭР, БАРИЛГА, ХОТ БАЙГУУЛАЛТЫН САЙД	216,321.6	239,468.0	251,149.4
Урсгал зардал	20,228.5	22,393.0	23,485.3
Хөрөнгийн зардал	177,162.5	196,118.8	205,685.6
Эргэж төлөгдөх цэвэр зээл	18,930.7	20,956.2	21,978.5



ЭРДЭС БАЯЛАГ, ЭРЧИМ ХҮЧНИЙ САЙД	129,834.3	143,726.6	150,737.6
Урсгал зардал	44,540.2	49,306.0	51,711.2
Хөрөнгийн зардал	85,294.1	94,420.6	99,026.4
Эргэж төлөгдөх цэвэр зээл	-	-	-
НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙД	337,338.5	373,433.7	391,650.0
Урсгал зардал	336,296.1	372,279.7	390,439.7
Хөрөнгийн зардал	1,042.4	1,154.0	1,210.3
Эргэж төлөгдөх цэвэр зээл	-	-	-
ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЙД	177,692.4	196,705.4	206,300.8
Урсгал зардал	81,898.8	90,661.9	95,084.5
Хөрөнгийн зардал	95,793.6	106,043.5	111,216.4
Эргэж төлөгдөх цэвэр зээл	-	-	-
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД	296,320.6	328,026.9	344,028.2
Урсгал зардал	230,919.0	255,627.3	268,096.9
Хөрөнгийн зардал	65,401.6	72,399.6	75,931.3
Эргэж төлөгдөх цэвэр зээл	-	-	-
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА	324.2	358.9	376.4
Урсгал зардал	324.2	358.9	376.4
Хөрөнгийн зардал	-	-	-
Эргэж төлөгдөх цэвэр зээл	-	-	-
СОНГУУЛИЙН ЕРӨНХИЙ ХОРООНЫ ДАРГА	192.6	213.2	223.6
Урсгал зардал	192.6	213.2	223.6
Хөрөнгийн зардал	-	-	-
Эргэж төлөгдөх цэвэр зээл	-	-	-
ХҮНИЙ ЭРХИЙН ҮНДЭСНИЙ КОМИССЫН ДАРГА	260.5	288.4	302.5
Урсгал зардал	260.5	288.4	302.5
Хөрөнгийн зардал	-	-	-
Эргэж төлөгдөх цэвэр зээл	-	-	-



УЛСЫН ЕРӨНХИЙ АУДИТОР			
	814.2	901.4	945.3
Урсгал зардал	764.2	846.0	887.3
Хөрөнгийн зардал	50.0	55.4	58.1
Эргэж төлөгдөх цэвэр зээл	-	-	-
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ДАРГА	998.6	1,105.4	1,159.3
Урсгал зардал	998.6	1,105.4	1,159.3
Хөрөнгийн зардал	-	-	-
Эргэж төлөгдөх цэвэр зээл	-	-	-
ҮНДЭСНИЙ СТАТИСТИКИЙН ХОРООНЫ ДАРГА	4,052.3	4,485.9	4,704.8
Урсгал зардал	3,960.9	4,384.8	4,598.7
Хөрөнгийн зардал	91.4	101.2	106.1
Эргэж төлөгдөх цэвэр зээл	-	-	-
ЦАГААТГАХ АЖЛЫГ УДИРДАН ЗОХИОН БАЙГУУЛАХ УЛСЫН КОМИССЫН ДАРГА	558.0	617.7	647.8
Урсгал зардал	558.0	617.7	647.8
Хөрөнгийн зардал	-	-	-
Эргэж төлөгдөх цэвэр зээл	-	-	-
МОНГОЛЫН ҮНДЭСНИЙ ОЛОН НИЙТИЙН РАДИО, ТЕЛЕВИЗИЙН ЗАХИРАЛ	4,204.9	4,654.8	4,881.9
Урсгал зардал	3,704.9	4,101.3	4,301.4
Хөрөнгийн зардал	500.0	553.5	580.5
Эргэж төлөгдөх цэвэр зээл	-	-	-
АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ГАЗРЫН ДАРГА	3,243.4	3,590.5	3,765.6
Урсгал зардал	3,152.0	3,489.3	3,659.5
Хөрөнгийн зардал	91.4	101.2	106.1
Эргэж төлөгдөх цэвэр зээл	-	-	-

**Б. НИЙГМИЙН ДААТГАЛЫН
САНГИЙН ТӨСӨВ**

НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙД	439,788.8	486,846.2	510,594.8
Урсгал зардал	437,163.8	483,940.3	507,547.2
Хөрөнгийн зардал	2,625.0	2,905.9	3,047.6
Эргэж төлөгдөх цэвэр зээл	-	-	-
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД	81,564.4	90,291.8	94,696.2
Урсгал зардал	81,564.4	90,291.8	94,696.2
Хөрөнгийн зардал	-	-	-
Эргэж төлөгдөх цэвэр зээл	-	-	-

**В. ХҮНИЙ ХӨГЖИЛ САНГИЙН
ТӨСӨВ**

САНГИЙН САЙД	390,700.0	432,504.9	453,602.7
Урсгал зардал	390,700.0	432,504.9	453,602.7
Хөрөнгийн зардал	-	-	-
Эргэж төлөгдөх цэвэр зээл	-	-	-
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД	10,906.1	12,073.0	12,661.9
Урсгал зардал	10,906.1	12,073.0	12,661.9
Хөрөнгийн зардал	-	-	-
Эргэж төлөгдөх цэвэр зээл	-	-	-

Г. ОРОН НУТГИЙН ТӨСӨВ

АРХАНГАЙ	5,346.0	5,918.0	6,206.7
БАЯН-ӨЛГИЙ	4,361.9	4,828.6	5,064.2
БАЯНХОНГОР	5,550.2	6,144.1	6,443.8
БУЛГАН	4,669.7	5,169.4	5,421.5
ГОВЬ-АЛТАЙ	5,275.8	5,840.3	6,125.2
ДОРНОГОВЬ	4,122.7	4,563.8	4,786.4
ДОРНОД	3,905.6	4,323.5	4,534.4
ДУНДГОВЬ	3,634.1	4,023.0	4,219.2

ЗАВХАН	5,428.1	6,008.9	6,302.0
ӨВӨРХАНГАЙ	5,666.4	6,272.7	6,578.7
ӨМНӨГОВЬ	4,333.9	4,797.7	5,031.7
СҮХБААТАР	3,722.1	4,120.4	4,321.3
СЭЛЭНГЭ	5,972.8	6,611.9	6,934.4
ТӨВ	6,713.2	7,431.5	7,794.0
УВС	5,250.8	5,812.6	6,096.2
ХОВД	4,949.7	5,479.4	5,746.7
ХӨВСГӨЛ	6,329.9	7,007.2	7,349.1
ХЭНТИЙ	4,520.0	5,003.7	5,247.8
ДАРХАН-УУЛ	3,761.4	4,163.8	4,367.0
УЛААНБААТАР	70,166.3	77,674.1	81,463.1
ОРХОН	3,673.7	4,066.8	4,265.2
ГОВЬСҮМБЭР	1,633.8	1,808.6	1,896.9

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2010 оны 7 дугаар
сарын 20-ны өдөр

Дугаар 197

Улаанбаатар
хот

Түр журам батлах тухай

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 5.1.1, 22.1.1-д заасныг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "2009-2010 оны өвөл, хавар тохиолдсон зудын улмаас амьжиргааны эх үүсвэрээ алдсан зарим малчин өрхийг малжуулах түр журам"-ыг хавсралт ёсоор баталсугай.

2. Энэ тогтоолыг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, дүнг оны эгсгст ганилцуулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай, аймгийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН
ҮЙЛДВЭРИЙН САЙД**

Т.БАДАМЖУНАЙ

**2009-2010 ОНЫ ӨВӨЛ, ХАВАР ТОХИОЛДСОН ЗУДЫН УЛМААС
АМЬЖИРГААНЫ ЭХ ҮҮСВЭРЭЭ АЛДСАН ЗАРИМ МАЛЧИН
ӨРХИЙГ МАЛЖУУЛАХ ТҮР ЖУРАМ****Нэг. Нийтлэг үндэслэл**

1. Зудын улмаас 2009–2010 оны өвөл, хавар мал нь хорогдож, малгүй болсон зарим малчин өрхийг малжуулж (цаашид "малжуулах" гэх), амьжиргааны эх үүсвэртэй болгоход энэхүү журмын зорилго оршино.

2. Улсын онцгой комиссын шийдвэрийн дагуу томилогдсон ажлын хэсгийн дүгнэлтээр гамшгийн болон зудын зэрэглэлд орсон сумдын малгүй болсон малчин өрхийн 50 хүртэл хувийг малжуулж, бусдыг нь өөр салбарт мэргэшүүлэн шилжүүлэх чиглэл баримтална.

3. Малжуулах ажлыг дараахь хэлбэрээр зохион байгуулна:

3.1. улсын болон орон нутгийн төсвийн хөрөнгөөр малжуулах;

3.2. дотоодын байгууллага, аж ахуйн нэгж, нутгийн зөвлөл, иргэд, гадаад улс, олон улсын байгууллагын хандив, тусламжийн хөрөнгөөр малжуулах;

3.3. олон мал бүхий малчдын малыг түрээсээр маллуулах замаар малжуулах;

3.4. мал бүхий иргэд төрөл төрөгсөд болон найз нөхдөө малжуулах хөдөлгөөнийг сум, орон нутгийн зүгээс өрнүүлэх.

4. Малжуулахад шаардагдах нийт хөрөнгийн 40 хувийг улсын төсвөөс, 40 хувийг олон улсын байгууллага, гадаад орны хандив, тусламжаас, 20 хувийг орон нутгийн нөөц бололцоонд тулгуурлан гаргана.

5. Санхүүгийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь улсын төсвөөс малжуулах арга хэмжээнд зориулж батлагдсан хөрөнгийг хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагын гаргасан малжуулах өрхийн тоог үндэслэн тухайн сумын Засаг даргын Тамгын газрын тусгай дансанд шилжүүлнэ.

6. Хөрөнгийн бусад эх үүсвэрээр малжуулах арга хэмжээг энэхүү түр журмыг баримтлан зохион байгуулж болно.

7. Малжуулах арга хэмжээнд хамрагдах малчин өрхийг энэхүү түр журамд заасан шалгуураар сонгон авч, өрх нэг бүртэй гэрээ байгуулж ажиллана.

8. Улсын төсвийн хөрөнгөөр малжуулах арга хэмжээний хүрээнд малыг тухайн өрх 5 жилийн дотор малаар нь, эсхүл мөнгөн хэлбэрээр эргүүлэн өгч аймгийн "Мал хамгаалах" санд төвлөрүүлэхээр гэрээ байгуулна.



Хоёр. Малжуулах төсөлд хамрагдах өрхийг сонгох шалгуур үзүүлэлт

9. Малжуулах арга хэмжээнд хамрагдах өрхийг сонгохдоо дараахь шалгуур үзүүлэлтийг харгалзана:

9.1. хонин толгойд шилжүүлснээр өмнөх жилийн эцэст 200-гаас цөөнгүй малтай байсан нь мал тооллогын албан ёсны бүртгэлээр баталгаажсан байх;

9.2. тухайн өрх нь 2-оос цөөнгүй хөдөлмөрийн чадвартай хүнтэй бөгөөд мал өвөлжүүлж, хаваржуулах өөрийн өмчийн болон эзэмшлийн хашаа, хороотой байх;

9.3. мал аж ахуйн үйлдвэрлэл дээр сүүлийн 3 жилээс доошгүй жил тасралтгүй ажилласан туршлагатай байх;

9.4. авсан малаа үр төлөөр нь өсгөж эргүүлэн төлж чадахыг нь нотолсон тухайн орон нутгийн 2 малчны тодорхойлолттой байх;

9.5. банкинд хугацаа хэтэрсэн зээлийн өргүй байх.

Гурав. Малгүй болсон өрхөд олгох малыг сонгох

10. Малчдад олгох малыг дараахь шалгуур үзүүлэлтийг харгалзан сонгож авна:

10.1. малжуулахаар олгох мал нь өвчин эмгэггүй болохыг мэргэжлийн байгууллагаар баталгаажсан, тухайн бүс нутгийн байгаль, цаг уурт зохицсон байх;

10.2. хээлтүүлэгч мал нь мэргэжлийн байгууллагаар баталгаажсан, хээлтэгч нь тухайн үүлдрийн стандартыг хангасан, гурваас цөөнгүй жил үр төл өгөх боломжтой байх;

10.3. энэхүү журмын 10.1, 10.2-т заасан шаардлагыг хангасан малыг сум, орон нутгийнхаа олон малтай өрхөөс худалдан авахаар гэрээ байгуулсан байх;

10.4. шаардлагатай байгаа малыг тухайн сум, аймгаас нийлүүлэх боломжгүй бол бүсийн хэмжээнд сайжруулагчаар ашиглаж болох цөм сүргийн мал авахаар зэргэлдээ сум, аймагтай гэрээ байгуулсан байх.

11. Малыг сонгох, малчдад мал олгох ажлыг сумын засаг даргын Тамгын газар мэргэжлийн байгууллагын тусламжтайгаар зохион байгуулна.

Дөрөв. Малжуулах ажлыг зохицуулах, хяналт тавих

12. Улсын онцгой комиссын шийдвэрийн дагуу томилогдсон ажлын хэсгийн дүгнэлтээр гамшгийн болон зудын зэрэглэл тогтоогдсон сумдын зудын улмаас хорогдсон мал болон малгүй болсон малчин өрхийн тоог



харгалзан тухайн сум, аймгийн малжуулах өрхийн тоог хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага тогтооно.

13. Олон улсын байгууллага, гадаад орны тусламж, хандиваар санхүүжүүлэх төсөл, хөтөлбөртэй холбоотой асуудлыг гадаад хэргийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, төсвийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагатай хамтран яриа хэлэлцээ хийсний үндсэн дээр шийдвэрлэнэ.

14. Гадаад орон, олон улсын байгууллагын санхүүжилтээр малжуулах өрхийн тоог хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага гаргана.

15. Малгүй болсон өрхийг орон нутгийн нөөц бололцоонд тулгуурлан малжуулах хөрөнгийг аймаг, сумын Засаг дарга бүрдүүлнэ.

16. Энэхүү журмын 3.3, 3.4-т заасны дагуу малжуулах хөдөлгөөнийг сумын Засаг дарга зохион байгуулна.

17. Малжуулах ажлын хүрээнд зохион байгуулах үйл ажиллагааны явцад мэргэжлийн хяналтын байгууллага хяналт тавьж ажиллана.

Тав. Малжуулах ажлыг зохион байгуулах

18. Тухайн малчин нь малжуулах төсөлд хамрагдах хүсэлтээ багийн Засаг даргаар уламжлан Халамжийн тухай хуулийн 9 дүгээр зүйлд заасан сумын Амьжиргааг дэмжих орон тооны бус зөвлөлд гаргана.

19. Сумын амьжиргааг дэмжих зөвлөл нь малжуулах өрхийг сонгож нэрээр нь гаргана.

20. Амьжиргааг дэмжих зөвлөл энэхүү журмыг малчдад танилцуулж уг төсөлд хамрагдах хүсэлтэй малчдаас ирүүлсэн өргөдлийг судалж, шаардлагатай бол нэмэлт лавлагааг өөрөөс нь болон холбогдох албан тушаалтнаас авсны үндсэн дээр хэлэлцэн сонгож малжуулах дарааллыг тогтооно.

21. Энэхүү журмын 9-д заасан шалгуур үзүүлэлтийг хангаж, мөн журмын 8, 23-т заасныг хүлээн зөвшөөрсөн нэг өрхөд журмын 10.1-10.4 дэх шаардлагыг хангасан 70 хүртэлх толгой мал /үхэр-3, морь-2, хонь-40, ямаа-45/ худалдан авч гэрээгээр олгоно (Тайлбар: Малаг хонин толгойд шилжүүлэхдээ адууг-7, үхрийг-6, тэмээг-5, хонийг-1, ямааг-0.9 гэсэн илтгэлцүүрийг ашиглана).

22. Тухайн малчин нь нийт үнийн дүнд багтаан авах малынхаа тоог өөрчлөн сонголт хийж болно.

23. Тухайн малчин авсан малаа үр төлөөр нь өсгөж 3 дахь жилдээ үнийн дүнгийн 40 хувийг, 4 дэх жилдээ 30 хувийг, 5 дахь жилдээ 30 хувийг малаар нь буюу мөнгөн хэлбэрээр барагдуулахаар тооцож сумын Амьжиргааг дэмжих зөвлөл, малчны хооронд гэрээ байгуулж зохицуулна.

24. Малчинтай байгуулах гэрээний загварыг хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага батална.



25. Амьжиргааг дэмжих зөвлөл, малчны хооронд байгуулсан гэрээний биелэлтэд сум, багийн Засаг дарга хяналт тавин ажиллаж, мөнгөн төлбөрийг нь аймгийн "Мал хамгаалах сан"-гийн дансанд шилжүүлж, харин малаар нь өгөх төлбөрийг аймгийн "Мал хамгаалах сан"-д тухайн малын зах зээлийн үнээр бүртгэн авч, зохих журмын дагуу тухайн сумын малжуулах төсөлд хамрагдах дараагийн малчинтай гэрээ байгуулж болно.

26. Малжуулах ажлын явц, үр дүнгийн тайланг сумын Засаг дарга аймагт, аймгийн Засаг дарга хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад 2010 онд сар бүр тайлагнана. Хөдөө аж ахуйн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага нь малжуулах ажлын үр дүнг санхүүгийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллага, Засгийн газарт тайлагнана.

27. Аймгийн "Мал хамгаалах сан"-гийн бүрдэлт, сангийн зарцуулалтын тайланг Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн дагуу санхүүгийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагад гаргаж өгнө.

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2010 оны 8 дугаар
сарын 18-ны өдөр

Дугаар 202

Улаанбаатар
хот

Төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. "Монгол Улсын Ерөнхий сайд Архангай, Хөвсгөл, Увс, Баян-Өлгий, Ховд, Говь-Алтай, Завхан, Баянхонгор, Өвөрхангай аймагт ажилласан мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөө"-г хавсралт ёсоор баталсугай.

2. Ерөнхий сайдын орон нутагт ажилласан мөрөөр дараахь арга хэмжээ авч хэрэгжүүлэхийг холбогдох сайд нарт даалгасугай.

2.1. Төвөөс алслагдсан баруун аймгийн иргэдийн амьжиргааны түвшинг дээшлүүлэх болон тогтвор суурьшилтай ажиллаж амьдрах нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор тэдгээрт алслагдсан бүсийн нэмэгдэл олгох асуудлыг судалж, санал боловсруулан 2010 оны IV улиралд багтаан Засгийн газарт танилцуулахыг Сангийн сайд С.Баярцогт, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Т.Ганди нарт;

2.2. Хүнсний бүтээгдэхүүний үнийн өсөлтийг хязгаарлах зорилгоор гол нэр төрлийн хүнсний бүтээгдэхүүний улсын нөөц бүрдүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг 2011 оны улсын төсөв болон эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөлд тусгахыг Сангийн сайд С.Баярцогт, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунцай нарт;

2.3. Хүнсний ногоо тарих, хадлан тэжээл бэлтгэх талаар иргэдээс гарч байгаа санаачилгыг дэмжиж, бага оврын тракторыг дагалдах тоног төхөөрөмжийн хамт хөнгөлөлттэй үнээр нийлүүлэх асуудлыг судлан шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг 2011 оны улсын төсөв, зээл, тусламжийн хүрээнд санхүүжүүлэх арга хэмжээ авахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай;

2.4. Хөдөө аж ахуйн бирж болон мах боловсруулах үйлдвэрийн сүлжээ байгуулах, малгүй болсон малчдын банкны зээлийн өрийн зарим хэсгийг Хүний хөгжил сангаас иргэн бүрт хүртээх хишиг, хувиас нөхөн төлүүлэх асуудлыг судалж, саналаа 2010 оны 10 дугаар сард багтаан Засгийн газарт танилцуулахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Т.Ганди нарт;

2.5. Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх сангийн үйл ажиллагааг өргөжүүлж, сангаас олгох зээлийн хэмжээ, нөхцөл, шаардлагыг өөрчлөх асуудлыг судалж, шийдвэрлэх талаар холбогдох арга хэмжээ авахыг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд Т.Бадамжунай;

2.6. Байгаль орчныг хамгаалах чиглэлээр иргэд, төрийн бус байгууллагаас тавьсан санал, хүсэлтийг нэгбүрчлэн судалж, холбогдох байгууллагуудтай хамтарч ажиллан шийдвэрлэх арга хэмжээ авахыг Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Л.Гансүхэд;

2.7. Могойнголын нүүрсний уурхайг түшиглэн дулааны цахилгаан станц барих, Тайшир, Дөргөний усан цахилгаан станцын талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээний саналыг боловсруулан 2010 оны 9 дүгээр сард багтаан Засгийн газарт танилцуулахыг Эрдэс баялаг, эрчим хүчний сайд Д.Зоригтод.

3. Энэхүү тогтоолын 1 дүгээр зүйлээр баталсан төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээг санхүүжүүлэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн улсын төсөв, эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлийн төсөлд тусгах арга хэмжээ авч байхыг Сангийн сайд С.Баярцогт, холбогдох сайд нарт, төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, явц, үр дүнг жил бүрийн II улиралд багтаан Засгийн газарт танилцуулж байхыг Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Ч.Хүрэлбаатарт тус тус даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ САЙД**

С.БАТБОЛД

**МОНГОЛ УЛСЫН САЙД,
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ
ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГА**

Ч.ХҮРЭЛБААТАР

Засгийн газрын 2010 оны 202 дугаар
тогтоолын хавсралт

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД С.БАТБОЛД АРХАНГАЙ,
ХӨВСГӨЛ, УВС, БАЯН-ӨЛГИЙ, ХОВД, ГОВЬ-АЛТАЙ, ЗАВХАН,
БАЯНХОНГОР, ӨВӨРХАНГАЙ АЙМАГТ АЖИЛЛАСАН
МӨРӨӨР АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

№	Авах арга хэмжээ	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцах албан тушаалтан
Нэг, Архангай аймаг			
1	Булган сумын Сангийн толгойн модон гүүрийг төмөр бетон гүүр болгох асуудлыг судлах	2011 он	Х.Баттулга
2	Цэцэрлэг хотоор дайран өнгөрч байгаа улсын чанартай 2 км автозамыг хатуу хучилттай болгох асуудлыг судлах	2011 он	Х.Баттулга
3	Аймгийн төвийн номын сан болон 1 дүгээр цэцэрлэгийн 150 хүүхдийн барилга барихад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг судалж шийдвэрлэх	2011 он	Е.Отгонбаяр С.Баярцогт
Хоёр, Хөвсгөл аймаг			
1	Аймгийн нэгдсэн эмнэлгийн барилгын засварт шаардагдах 300.0 сая төгрөгийн асуудлыг шийдвэрлэх	2011 он	С.Ламбаа С.Баярцогт
2	Хатгал-Мөрөнгийн автозамыг дуусгахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг судалж шийдвэрлэх	2011 он	Х.Баттулга С.Баярцогт
3	Увс-Тэрхийн цагаан нуур ниглэлний хатуу хучилттай автозамыг өөрийн хөрөнгөөр гүйцэтгэн дараа төлөгдөх нөхцөлтэйгээр хувийн хэвшлээр бариулах асуудлыг судлах	2011 он	Х.Баттулга С.Баярцогт
4	Цэцэрлэг суманд дунд оврын трактор 1-ийг олгох	2010 он	Т.Бадамжунай



Гурав. Увс аймаг

1	Улаангом хотод дулааны 2 дахь эх үүсвэр шинээр барих асуудлыг судалж шийдвэрлэх	2011 он	Д.Зоригт С.Баярцогт Ч.Хүрэлбаатар
2	Улаангом хотод баригдаж байгаа Ю.Цэдэнбалын цогцолборт шаардлагатай 300.0 сая төгрөгийн асуудлыг шийдвэрлэх	2010 он	Ч.Хүрэлбаатар С.Баярцогт
3	Улаангом-Хяргас нуурын дагуухь улсын чанартай 100 км замыг хатуу хүчилттай болгох асуудлыг судалж шийдвэрлэх	2011 он	Х.Баттулга С.Баярцогт
4	Боршоогийн хилийн боомтыг хилийн боомтын үлгэрчилсэн ерөнхий төлөвлөгөөний дагуу тохижуулахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг судалж шийдвэрлэх	2011 он	С.Баярцогт Х.Баттулга Ч.Хүрэлбаатар
5	Улаангомьн коллежийн 180 оюутныг Улаанбаатар хотод шилжүүгэхэд шаардагдах 59.0 сая төгрөгийн асуудлыг шийдвэрлэх	2010 он	Е.Отгонбаяр
6	"Аривжих-Увс" ХХХ-ийн барьсан 100 хүүхдийн цэцэрлөгийн нэг суралцагчид ногдох хувьсах зардлыг олгох	2011 он	Е.Отгонбаяр
7	Аймгийн ногдсон эмнэлгийн их засварт шаардагдах 300.0 сая төгрөгийн асуудлыг шийдвэрлэх	2011 он	С.Ламбаа
8	Шино-Ирээдүй цогцолборын барилгын засварт шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг судалж шийдвэрлэх	2011 он	Е.Отгонбаяр
9	Нисэх буудлын хатуу хүчилттай хөөрч, буух зурвас болон хамгаалалтын хашаа, үерийн далан барих ажлыг хугацаанд нь чанарын өндөр түвшинд хийж гүйцэтгэхэд шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг судалж шийдвэрлэх	2010 оны IX сард	Х.Баттулга С.Баярцогт



Дөрөв. Баян-Өлгий аймаг

1	Өлгий сумын ахлах 1 дүгээр сургуулийн 920 суудалтай хичээлийн байр барих асуудлыг судалж шийдвэрлэх	2010-2011 он	Е.Отгонбаяр С.Баярцогт
2	Казах иргэд эх хэл дээрээ радио, телевизийн мэдээлэл авах сувгийн зөвшөөрөл олгох асуудлыг судлах	2011 он	Ч.Хүрэлбаатар Ж.Сансар
3	Хилийн Даян, Улаан-Уулын боомтоос Цагааннуур, Улаанбайшинтын боомт хүртэлх хатуу хүчилтэй автозамыг барих асуудлыг судлах	2011 оны I улиралд	Х.Баттулга С.Баярцогт
4	Аймаг дахь радио өргөн нэвтрүүлгийн станцын тоног төхөөрөмжийг их бүрэн шинэчлэх асуудлыг судлах	2011 он	С.Баярцогт Ж.Сансар
5	Аймгийн номын сангийн барилга барихад шаардагдах 300.0 сая төгрөгийн асуудлыг шийдвэрлэх	2011 он	Е.Отгонбаяр
6	Өлгий хотод хүүхэд, залуучуудын парк шинээр байгуулах асуудлыг судалж шийдвэрлэх	2011 он	М.Энхболд
7	Шинээр ашиглалтад орох спорт цогцолборт спортын хэрэгсэл, тоног төхөөрөмж, эд хогшил авахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг судалж шийдвэрлэх	2010-2011 он	С.Ламбаа
8	Булган сумыг Ховд аймгийн Дуут сумаас агаараар цахилгаан дамжуулах 15 кВ-ын шугамаа холбоход шаардагдах нэмэлт хөрөнгийн эх үүсвэрийг судалж шийдвэрлэх	2011 он	Д.Зоригт

Тав. Ховд аймаг

1	БНХАУ-аас Алтай, Үенч, Булган сумдын импортолж байгаа цахилгааны үнэ, үүсэн өрийн асуудлыг судалж шийдвэрлэх	2010 оны IX сард	Д.Зоригт С.Баярцогт
---	--	---------------------	------------------------



2	Өвлийн болтгал хангах хүрээнд дулааны станцын зуухны шинэчлэлд шаардагдах 270.0 сая төгрөгийн эх үүсвэрийг судалж шийдвэрлэх	2010 оны IX сард	С.Баярцогт Д.Зоригт
3	Аймгийн төвд дулааны 2 дахь эх үүсвэр барих шаардлагатай эсэхийг судлах	2010 он	Д.Зоригт
4	Хөшөөтийн уурхайгаас жилд нэг сая тонн баяжуулсан нүүрс экспортлох асуудлыг судалж шийдвэрлэх	2010-2011 он	Д.Зоригт
5	Булганы боомтын шинээр барих өргөтгөлийн асуудлыг судлан концессын гэрээ байгуулах ажлыг эхлүүлэх	2010 оны IX сард	Ч.Хуралбаатар Д.Сугар
6	"Ахмадын соёлын өргөө" барихад шаардагдах 196.0 сая төгрөгийн нэмэлт хөрөнгийн асуудлыг шийдвэрлэх	2010 оны IX сард	С.Баярцогт
7	Булган суманд махны үйлдвэр төрхувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд барих асуудлыг судалж шийдвэрлэх	2011 он	Т.Бадамжунай Д.Сугар
8	Цардуулын болон хүнсний ногоо дахин боловсруулах үйлдвэр төрхувийн хэвшлийн түншлэлийн хүрээнд барих асуудлыг судалж шийдвэрлэх	2011 он	Т.Бадамжунай
9	Хөвд хотын замын шинэчлэл, засварт шаардагдах 4.0 тэрбум, цэвэрлэх байгууламжийн өргөтгөлд шаардагдах 1.5 тэрбум төгрөгийг 2011 оны улсын төсвийн төсөлд тусгах	2011 он	Х.Баттулга С.Баярцогт
Зургаа. Говь-Алтай аймаг			
1	Тайширын усан цахилгаан станцыг бүрэн хүчин чадлаар нь ажиллуулах болтгэлийг хангах, туршилт хийхэд шаардагдах 350.0 сая төгрөгийн асуудлыг шийдвэрлэх	2010 оны VIII сард	Д.Зоригт С.Баярцогт
2	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр баригдсан Алтай хотын ундны усны шинэ худгийг төвийн шугамтай холбох 2.2 км шугам татахад шаардагдах 280.0 сая төгрөгийн асуудлыг шийдвэрлэх	2010 он	С.Баярцогт



3	"Алтай" чуулгын барилгын ажилд дутагдаж байгаа 1.718.0 сая төгрөгийн асуудлыг шийдвэрлэх	2011 он	Ё.Отгонбаяр С.Баярцогт
4	Уламжлалт анагаах ухааны төвийн барилгын гадна тохижилт, шугам сүлжээ болон тоног төхөөрөмж худалдан авахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг судалж шийдвэрлэх	2011 он	С.Ламбаа
5	Тайшир суманд соёлын төвийн барилга шинээр барих хөрөнгийн эх үүсвэрийг судалж шийдвэрлэх	2011 он	Ё.Отгонбаяр С.Баярцогт
6	Тайшир суманд газар тариалан эрхлэхэд зориулж хөрс боловсруулах дунд оврын трактор, комбайны иж бүрдэл олгох	2010 оны IX сард	Т.Бадамжунай
7	Тайшир сумаас аймгийн төв рүү цэвэр ус дамжуулах 45 км магистраль шугам барих техник-эдийн засгийн үндэслэлийг боловсруулах	2011-2012 он	Д.Зоригт Х.Баттулга
8	Тайширын усан цахилгаан станцын ажилчдын орон сууц, конторын барилгыг барихад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг судалж шийдвэрлэх	2011 он	Д.Зоригт С.Баярцогт
9	Сумдын 0.4 хвт-ын цахилгаан түгээх шугам сүлжээг шинэчлэх ажлыг дуусгах	2011 оны эхний хагаст	Д.Зоригт
10	Алтай хотын дулаан, цэвэр, бохир усны шугам сүлжээг иж бүрэн шинэчлэх асуудлыг судалж шийдвэрлэх	2011 он	Х.Баттулга
11	Халдвартын эмнэлэг болон амаржих газар шинээр барих асуудлыг судалж шийдвэрлэх	2011-2012 он	С.Ламбаа
Долоо. Завхан аймаг			
1	Улиастай-Доной чиглэлийн 35 км хатуу хучилттай зам барих хөрөнгийн эх үүсвэрийг судалж шийдвэрлэх	2011 он	Х.Баттулга С.Баярцогт
2	Улиастай хотод 4 км хатуу хучилттай зам барих хөрөнгийн эх үүсвэрийг судалж шийдвэрлэх	2011 он	Х.Баттулга



3	Халдвартын эмнэлэг болон амаржих газар шинээр барих асуудлыг судалж шийдвэрлэх	2011-2012 он	С.Ламбаа
4	Отгон сумын төвийн цахилгааны нам хүчдэлийн шугамыг шинэчлэх хөрөнгийн эх үүсвэрийг судалж шийдвэрлэх	2011 он	Д.Зоригт
5	Аймгийн төвийн гэр хорооллын 2,5 км замыг засварлахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг судалж шийдвэрлэх	2010 оны VIII сард	Х.Баттулга С.Баярцогт
6	Аймгийн цаг уур, орны шиожилгээний албаны конторын их засварт шаардагдах 70.0 сая төгрөгийг 2011 оны улсын төсвийн төсөлд тусгах	2010 он	Л.Гансүх С.Баярцогт
Найм, Баянхонгор аймаг			
1	Аймгийн халдвартын эмнэлэг шинээр барих хөрөнгийн эх үүсвэрийг судалж шийдвэрлэх	2011 он	С.Ламбаа С.Баярцогт
2	Арвайхээр-Баянхонгор чиглэлийн автозамыг барьж дуусгах хөрөнгийн эх үүсвэрийг судалж шийдвэрлэх	2011 он	Х.Баттулга
3	Баян-Өндөр, Шиожинст, Баянцагаан сумдыг цахилгааны найдвартай эх үүсвэрээр хангах арга хэмжээ авах	2011 он	Д.Зоригт
Ес, Өвөрхангай аймаг			
1	Арвайхээр хотын дулаан, цэвэр, бохир усны инженерийн шугам сүлжээг шинэчлэн өргөтгөхөд шаардагдах 3.4 тэрбум төгрөгийн асуудлыг шийдвэрлэх	2011 он	Д.Зоригт Х.Баттулга С.Баярцогт
2	Сайн ноён хан Т.Намансүрэнгийн музейг барьж байгуулахад шаардагдах 240.0 сая төгрөгийн асуудлыг шийдвэрлэх	2012 он	Е.Отгонбаяр С.Баярцогт
3	Нарийнтээл, Тарагт сумдад эмнэлэг шинээр барихад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг судалж шийдвэрлэх	2011 он	С.Ламбаа С.Баярцогт
4	Аймгийн дулааны цахилгаан станцын техник-эдийн засгийн үндэсгэл, зураг төсөл боловсруулахад шаардагдах 300.0 сая төгрөгийн асуудлыг шийдвэрлэх	2011 он	Д.Зоригт С.Баярцогт



5	Богд сумыг төвийн эрчим хүний нэгдсэн сүлжээнд холбох асуудлыг судалж шийдвэрлэх	2011 он	Д.Зоригт С.Баярцогт
6	Хархорин суманд спортын цогцолбор шинээр барих асуудлыг судалж шийдвэрлэх	2011 он	С.Ламбаа С.Баярцогт
7	Орхон голын ай сав газарт ашигт малтмал олборлож байгаа аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагааг хянан шалгаж, байнгын хяналт тавьж ажиллах	2010 он	Л.Гансүх Я.Содбаатар
8	Өндөр гэгээн Занабазарын хөшөө бүхий цэцэрлэгт хүрээлэн байгуулахад шаардагдах хөрөнгийн эх үүсвэрийг судалж шийдвэрлэх	2011 он	М.Энхболд С.Баярцогт
Арав. Бусад			
1	Оросын Холбооны Улсаас "Баруун бүсийн эрчим хүчний систем" ХК-ийн импортоор авч байгаа цахилгаан эрчим хүчийг гааль болон нэмэгдсэн өртгийн албан татвараас чөлөөлөх, 2008 онд үүссэн гааль болон нэмэгдсэн өртгийн албан татварын 418.9 сая төгрөг, 2009 онд үүссэн нэмэгдсэн өртгийн албан татварын 367.4 сая төгрөг, 2010 онд үүссэн гааль болон нэмэгдсэн өртгийн албан татварын 340.3 сая төгрөгийн, нийт 1.126.7 сая төгрөгийн өрийн асуудлыг судалж шийдвэрлэх	2010 он	С.Баярцогт Д.Зоригт

Залруулга

"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн 2010 оны 25 /646/ дугаарт нийтлөгдсөн Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай, Эм, эмнэлгийн хэрэгслийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн батлагдсан огноог 2010 оны 06 дугаар сарын 10-ны өдөр тэснийг 2010 оны 05 сарын 27-ны өдөр гэж залруулган уялжиге уу.

Хянг:

"Төрийн мэдээлэл" эмхтгэлийн редакция

Улаанбаатар-12, Төрийн ордон 124 тоот

И-мэйл: turin_medeelel@parliament.mn

Утас: 262420, 329612

Хэвлэлийн хуудас 1.5

Индекс: 14003



Улсын Их Хурлын Тамгын газрын хэвлэх хэсгээс хийлгэв,
Утас 329487